

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ  
2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН  
/хураангуй/**

2016.12.27

Улаанбаатар хот

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас дор дурдсан ажлыг 2016 онд хийж гүйцэтгэлээ.

**НЭГ. ЭРХ ЗҮЙН БОДЛОГО, СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХҮРЭЭНД:**

1. Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулга, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Хууль сахиулах ажиллагааны тухай, Зөрчлийг хянан шийдвэрлэх тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай зэрэг 7 хуулийн төслийг боловсруулан УИХ-аар батлуулсан.
2. Монгол Улсын хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Арбитрын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн төсөл, Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн шинэчилсэн найруулга, Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай, Цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дотоодын цэргийн тухай хуулийн төслийн хуулийн шинэчилсэн найруулга, хуулийн төсөл зэрэг 11 Үндэсний хөтөлбөрийн системийн тухай Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлсэн
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулга, Зөрчлийг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл, Прокурорын байгууллагын тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Үндэсний хөтөлбөрийн системийн тухай, Хууль сахиулах ажиллагааны тухай **зэрэг** хуулийн төслийг боловсруулж, яамд, холбогдох байгууллагуудаас санал авч өргөн барьсан байна.
4. Автобензин, дизелийн түлшний гаалийн албан татвар, онцгой албан татварын тухай, 2017 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг концессоор хэрэгжүүлэх жагсаалтыг батлах тухай, Газрын

биржийн ажиллах журам, Газрын биржийн ажиллах журмыг батлах тухай зэрэг Засгийн газрын **369** тогтоолын төсөлд холбогдох санал боловсруулан хүргүүлсэн.

5. “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”, “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”, “Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”, “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал” зэрэг 6 аргачлалыг Засгийн газрын тогтоолоор батлуулан, уг аргачлалуудаар УИХ, ЗГ, яамд, агентлагуудад Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн төсөлтэй хамтран сургалт зохион байгуулсан бөгөөд Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн талаарх сургалт, сурталчилгаа, мэдээллийг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж, иргэдэд зориулсан радио жүжгийг бэлтгэн 19 ангийг олон нийтэд түгээгээд байна.
6. Давхардсан тоогоор 18 удаагийн сургалтаар 26 байгууллагыг хамруулан 8 танилцуулга, хуулиудын 6 удаагийн хэвлэлтийг бэлтгэн гаргасан.

#### **БОДЛОГЫН УДИРДАМЖААР ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД:**

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Иргэний улс төрийн эрхийг хэрэгжүүлэх тухай, Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, УИХ-ын нэр бүхий гишүүдийн санаачилсан Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн төсөл, Монгол Улсын Статистикийн салбарыг 2016-2020 онд хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр батлах тухай, Орон сууц, гэр хорооллын дундын өмчлөлийн эд хөрөнгийн болон сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл зэрэг **76** хуулийн төсөлд Засгийн газраас өгөх санал, дүгнэлтийн төслийг боловсруулж, хуралдаанаар хэлэлцүүлэхээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.
2. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал, Аялал жуулчлалын тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх, Барилгын тухай хууль, Авто замын тухай хууль, Татварын ерөнхий хууль, Хувь хүний орлогын албан татварын хууль зэрэг нийт **127** хуулийн үзэл баримтлалыг хянан баталж хүргүүлэв.
3. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай, Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай зэрэг нийт **54** хууль, тогтоолын төслийг эцэслэн хянаж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгов.

#### **4. Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг хянаж бүртгэх талаар:**

Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын нэгдсэн санг Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сан

болгон өөрчлөхтэй холбогдуулан авах арга хэмжээний талаар Засгийн газрын 2016 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанд танилцууллаа.

Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгэлтэй нийт 960 шийдвэрээс сайдын 383 тушаал, агентлагийн даргын 56 тушаал, аймаг, нийслэлийн Засаг даргын 44 захирамж нийт 487 шийдвэр нь Захиргааны ерөнхий хуулийн шаардлага хангаагүй байх тул хүчингүй болгох, бүртгэлээс хасах, шинэчлэн баталж ирүүлэхээр Засгийн газрын 2016 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 41 дүгээр тэмдэглэлийн хамт албан бичгээр холбогдох байгууллагуудад хүргүүлсний дагуу хуульд нийцээгүй актуудыг хүчингүй болгох тухай 21 шийдвэрийг хүлээн авч 88 актыг хүчингүй болгож, 4 актыг улсын нэгдсэн сангаас хасч холбогдох хариуг хүргүүлсэн.

Нийтээр дагаж мөрдүүлэхээр баталсан нийт 500 шийдвэрийг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзэж, ХЗДХ-ийн сайдын дүгнэлт хүргүүлж, нийт 13 шийдвэрийг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн.

Мөн сайд, Засаг даргын 7 шийдвэрийг захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгэх шаардлагагүй, 2 тушаалыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу бүрдэл хангуулахаар тус тус буцаасан.

Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэм хэмжээний акт сэдэвт сургалтыг төрийн байгууллагуудын нийт 390 гаруй албан хаагчдыг хамруулан хийсэн.

legalinfo цахим сангийн хүчингүй хувилбарт байгаа 1992-2014 оны хуулиудын хэлбэржилтийг засч, цахим сангийн нэмэлт өөрчлөлт гэсэн хувилбарт харагдахгүй байсан нэмэлт, өөрчлөлтийг нөхөж шинээр нэмж хийсэн.

Улсын бүртгэлд бүртгэгдсэн захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн хүчинтэй жагсаалтыг тухай бүр Хууль зүйн мэдээлэл сэтгүүлд нийтэлсэн.

#### **5. Хууль тогтоомжийн бүртгэл-лавламжийн үндэсний санг бүрдүүлэх, зохих журмын дагуу хөтлөх, системчлэх, картын санг бүрдүүлэх талаар:**

Хууль тогтоомжийн үндэсний санд хууль-276, УИХ-ын тогтоол-94, Ерөнхийлөгчийн зарлиг-19, ҮХЦ-ийн шийдвэр-9, Засгийн газрын тогтоол-487, Ерөнхий сайдын захирамж-16, нийт эрх зүйн 618 актыг бүртгэсэн. Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн санд бүртгэгдсэн актаас хуулиудын нэмэлт өөрчлөлт-232, УИХ болон Засгийн газрын тогтоол бусад актаар оруулсан өөрчлөлт-315, нийт 547 актаар 1141 эх хувь, эх сурвалжид хөдөлгөөнийг тусгаж, яамны дотоод сүлжээгээр нийтэд мэдээлж, тус яамны 128 ажилтан, гадны 27 байгууллагад 264 актаар лавлагаа, мэдээлэл өгсөн.

#### **ГУРАВ. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТААР ХАНГАХ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД:**

1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, Монгол Улсын Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх

үндсэн чиглэл, Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн хөгжлийн цогц бодлого, Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж, хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн биелэлт, Хууль зүйн сайдын эрхлэх хүрээний асуудлаар УИХ, Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөр, түүний төлөвлөгөөний хэрэгжилтийг гарган, хуулийн хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлсэн.

Засгийн газар шинээр байгуулагдсантай холбогдуулан үндсэн дээр “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө”, “Засгийн газрын 100 хоног”, “ХЗДХЯ-ны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлт хөтөлбөр”, ХЗДХЯ-ны 2017 оны төсөв зэргийг боловсруулж, бичгийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

Яамны Авлигын эсрэг 2016 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, албан хаагчдын 2015 оны Ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд АТГ-т хүргүүлсэн.

Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг баталсны дагуу тус яамны орон тоо, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлууллаа.

Хууль зүйн яам болон харьяа агентлаг, байгууллагын албан хаагчдын 2015 оны бүрэлдэхүүн хөдөлгөөн, Яамны ТАЗ-ийн салбар зөвлөлийн тайланг Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.

Сайдын тушаалаар 36 албан хаагчид зэрэг дэв, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 7 албан хаагчид тус тус олгуулж, хүний нөөцийн томилгоотой холбоотой Сайдын 46 тушаал, ТНБД-ын 76 тушаал, яамны ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлүүлэх чиглэлээр ТНБД-ын 27 тушаал гарч, 7 ажилтанд 11.900.000 төгрөгийн буцалтгүй тусламжийг олгосон.

Тус яамны Хууль зүйн бодлогын газрын даргын, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын болон Гадаадын иргэн, харьяатын газрын дэд даргын сул орон тоон дээр Төрийн албаны зөвлөлөөс дүгнэлт гаргуулан, Захиргааны хэм хэмжээний актын хяналт бүртгэлийн хэлтсийн дарга, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан тушаалд нэр дэвшигчдийг салбар зөвлөлийн дүгнэлт гаргаж, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны дарга, Хууль зүйн туслалцааны төвийн захирал, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын Дэд даргын сул орон тооны захиалгыг ТАЗ-д хүргүүлэн нийтэд нээлттэй зарлан, сонгон шалгаруулалт зохион байгуулж, дүгнэлт гаргуулан, тухайн албан тушаалд томилуулсан.

Тус яамны дэргэдэх төрийн албаны салбар зөвлөлийн хурлаар Яамны ёс зүйн хороог шинэчлэн байгууллаа.

2. Хүний нөөцийг бэхжүүлэх, чадавхижуулах зорилгоор төрийн албан хаагчдыг боловсролын зэрэг олгох болон ажлын байран дээрх сургалтыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулжээ.

3. Тайлангийн хугацаанд **345** хүн Төрийн одон медалиар, Хууль зүйн албаны тэргүүний ажилтан тэмдгээр **129**, Яамны Хүндэт жуух бичгээр **246**, Улын бүртгэлийн тэргүүний ажилтан тэмдгээр **4**, Цагдаагийн алдар тэмдгээр **73**, Хүндэт хилчин тэмдгээр **6**, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тэргүүний ажилтан тэмдгээр **5** хүн тус тус шагнагдсан байна.

4. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль болон тус яаманд хандаж иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журмын хүрээнд иргэд, байгууллагаас **356** өргөдөл, гомдол хүлээн авснаас дээд газраас **30**, иргэдээс биечлэн **267**, шуудангаар **89** өргөдөл, гомдол хүлээн авч, **328 (92.1%)** өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэн өргөдөл гаргагчид хариу өгч, хугацаа болоогүй **28 (7.9%)** өргөдөлд хяналт тавин ажиллаж байна.

Сайдын иргэд хүлээн авах уулзалтыг **2** удаа зохион байгуулж, **31** иргэнтэй биечлэн уулзаж, санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн байна.

5. Яамны Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөг ТНБД-аар батлуулан, Архивын улсын байцаагчийн 2015 оны 01/15 дугаартай дүгнэлт, яаман дээр хэрэгжиж буй цахим програмын хэрэглээний хэрэгжилт, Гадаадын их, дээд сургуульд суралцагчдыг сонгон шалгаруулах, суралцуулах журам, ажил хүлээлцэх журмын хэрэгжилтийг шалгасан.

Тайлангийн хугацаанд ирсэн албан бичиг нийт-**11016**, шууд буюу хариугүй- **8523**, үүнээс хариутай -**2492**, хугацаандаа шийдсэн-**2285**, хугацаа хоцорч шийдвэрлэсэн -**479**, хяналтанд байгаа хариутай **187**, шийдвэрлэгдээгүй **21** албан бичигт ажиллагаа хийж байна.

Тайлангийн хугацаанд гадны байгууллага, иргэдэд **33** удаа **300** гаруй хуудас, байгууллагын албан хаагчдад **130** удаа **1000** гаруй хуудас баримтын хуулбар олгож, 1992-2000 оны **300** гаруй, **70** гаруй хадгаламжийн **6763** хуудас баримтыг цахим хэлбэрт оруулсан.

6. Тус яамны нийт компьютер, техник хэрэгсэл, дотоод сүлжээ, Able систем, сервер, интернетийн өдөр тутмын хэвийн ажиллагааг ханган ажиллаж, Үр дүнгийн гэрээ, тушаал шийдвэр, шагнал дэд программуудыг нэвтрүүлж, My board, Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн жагсаалт, яамны хэмжээнд мөрдөгдөх дүрэм, журмууд зэрэг буланг тус тус шинээр үүсгэж, мэдээллээр тухай бүр баяжуулж, яамнаас боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн, боловсруулж буй хуулийн төсөл, үйл ажиллагааны тайланг тайлангууд буланд тус тус байршуулж, нийт **334** мэдээллийг оруулсан.

7. Яамны үйл ажиллагааг олон нийтэд хүргэх зорилгоор тус яамнаас боловсруулан батлуулсан, УИХ-д өргөн мэдүүлсэн, боловсруулалтын шатанд байгаа хуулиудын талаар болон үйл ажиллагааны талаарх мэдээллийг өдөр тутмын сонин, телевиз, цахим сайтаар нийт **220** гаруй мэдээ бэлтгэж, давхардсан тоогоор **150** гаруй мэдээг цахим орчинд

түгээсэн байна.

Яамны аппаратын нийт албан хаагчдад эмнэлгийн анхан шатны тусламж, нарийн мэргэжлийн эмч нарын тусламж авахад дэмжлэг үзүүлж, 2016 онд нийт ажилтнуудыг эмчийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, кабинетэд эмийн ба эмийн бус эмчилгээг цаг тухайд нь хийсэн байна.

### **ДӨРӨВ. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ТӨСӨВ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ТӨЛӨВЛӨХ, САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАЛТААР ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД:**

1. Төсвийн тухай хуулийн дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг 2016 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэл хугацаанд аудит хийлгэж Үндэсний аудитын газрын “зөрчилгүй” санал дүгнэлтийг хүлээн авсан.

Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний төсвийн 6 төвлөрүүлэн захирагч, 6 шууд захирагчид хамрах 23,968 орон тоо бүхий 235 төсөвт нэгжийн 11 хөтөлбөр арга хэмжээний нийт зарлагыг 413,290.1 сая төгрөг, эргэн төлөгдөх цэвэр зээлийг (22,177.1) сая төгрөг, нийт зарлага цэвэр зээлийн дүнг 391,406.3 сая төгрөгт багтааж, санхүүжүүлэх эх үүсвэрийн 395,390.1 сая төгрөгийг улсын төсвөөс, 962.5 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 16.705.7 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас, 500.0 сая төгрөгийг гадаадын зээлийн санхүүжилт, 9,744.4 сая төгрөгийг векселиэр санхүүжүүлэх (22.177.1) сая төгрөгийг төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөхөөр, харин улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 64,054.6 сая төгрөг байхаар тус тус тодотгон баталж, Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон Сангийн сайдын 2016 оны “Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” 375 дугаар тушаалаар батлагдсан зарлага, санхүүжилтийн хуваарьт өөрчлөлт оруулан ажилласан.

Төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсөвтэй харьцуулахад 93.8 хувь, олгосон санхүүжилттэй харьцуулахад 97.5 хувийн гүйцэтгэлтэй гарч, авлагын эхний үлдэгдэл 2,103.9 сая төгрөг байсан бөгөөд 1,274.6 сая төгрөгөөр буурч 829.3 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй гарч, өглөгийн эхний үлдэгдэл 8,084.2 сая төгрөг байсан бөгөөд хугацааны дундуур 357.9 сая төгрөгийн өглөг буурч 7,726.3 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

2. Хууль зүйн сайдын/хуучин нэрээр/багцад 2015 онд худалдан авсан бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэлийн нэгдсэн тайланг болон 2016 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг сайдын 2016 оны А/07 тушаалаар батлуулж, Сангийн яаманд хуулийн хугацаанд хүргүүлсэн.

Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний Цагдаагийн ерөнхий газрын харьяа Ховд

аймгийн Булган сум дах Сум дундын Цагдаагийн хэлтсийн барилгын 87,403,234 төгрөг, Булган аймгийн Бугат сумын цагдаагийн кобаны барилгын 39,100,000 төгрөг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын “Ялтныг ажлын байраар хангах үйлдвэрийн тоног төхөөрөмж” худалдан авсан 122,850,000 төгрөг, Архивын ерөнхий газрын “Архивын ерөнхий газрын архивын зориулалттай тавиур шүүгээ” худалдан авсан 3,658,500,000 төгрөгийн санхүүжилтийн эрхийг зохих журмын дагуу Сангийн яаманд уламжлан нээлгэсэн.

3. Хууль зүй, дотоод хэргийн яамны 2015 оны санхүүгийн тайланг харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж, Үндэсний аудитын газарт хүргүүлэн, “зөрчилгүй” санал дүгнэлт гарсан.

2016 онд нийт 23 удаагийн бодолтоор давхардсан тоогоор 154 албан хаагчид 1,410.1 сая төгрөгийн цалинг бодож, НДШ, ХХОАТ-ыг холбогдох байгууллагад төлж тайлагнасан бөгөөд ажилтнуудын Нийгмийн даатгалын болон Эрүүл мэндийн даатгалын дэвтэрт бичилт хийж, Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын хэлтсээр баталгаажуулсан.

Шилэн дансны тухай хууль болон Засгийн газрын тогтоолоор баталсан журмын дагуу тус яамтай холбоотой цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын буюу санхүүжилтийн 36, зарлагын 46 гүйлгээ, сар бүрийн батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, тухайн сарын төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт болон шаардлагатай бусад мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудас /[www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn)/-нд байршуулсан.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцын 2016 оны батлагдсан төсвийн хүрээнд харьяа төсвийн 43 байгууллагын 144 дансны төлбөр тооцоог цахим системээр 22,384 ширхэг баримтаар 155 тэрбум 103 сая төгрөгийн дүнтэй орлого, зарлагын гүйлгээг хянан бүртгэж, баталгаажуулсан.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцын төсвийн 200 гаруй байгууллагын 2016 оны төсвийн гүйцэтгэлийн мэдээг нэгтгэн, тайлбар тодруулгын хамт хуулийн хугацаанд Сангийн яаманд хүргүүлж, Фрий баланс программд бүртгэж, жижиг мөнгөн сангийн зарцуулалтын тайланг хянаж, журналд бүртгэн, эрхийг нээсэн.

### **ТАВ. ГЭРЭЭ, ЭРХ ЗҮЙ, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД:**

1. НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооноос ирүүлсэн нэмэлт мэдээллийн асуулгад хариуг бэлтгэн хүргүүлж, Женев хотод үндэсний илтгэлийг хэлэлцүүлж, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын ээлжит илтгэлийг НҮБ-ын Хүний эрхийн хороонд хүргүүлэн, дээрх хоёр конвенцийн хэрэгжилтийн явцын талаарх Европын холбооноос ирүүлсэн асуулгыг бэлтгэн хүргүүлсэн.

Монгол Улсын Засгийн газар, Эрдэнэс Таван Толгой ХК болон БНХАУ-ын Чалко Трейдинг Хонг Конг компани, Ти Ти Жи Би Си Өү компаний хооронд байгуулсан гэрээний талаар санал, дүгнэлт, Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Монгол Улсын Засгийн газар, Канад Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр,

Монгол Улсын Засгийн газар болон “Цэцэнс майнинг энд Энержи” ХХК, “Бодь Интернэшл” ХХК, “Power China Resource” ХХК-ний хооронд байгуулах “Бөөрөлжүүтийн цахилгаан станцын төсөлд санал өгч, холбогдох ажлын хэсэгт орж ажилласан.

2. “Ялтан шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонконгийн Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг байгуулж, УИХ-аар соёрхон батлуулав.

Тайлангийн хугацаанд гадаад, дотоодын байгууллагаас ирүүлсэн эрх зүйн туслалцааны талаар ирүүлсэн 177 албан бичиг, 14 өргөдөл, гомдолд холбогдох ажиллагаа хийн, эрх бүхий байгууллагуудад хүргүүлэх, шаардлагатай лавлагаа, мэдээлэл гаргуулах, орчуулгыг хянах, орчуулах, гэрээтэй холбоотой мэдээлэл өгөх зэргээр дэмжлэг үзүүлж ажилсан.

БНХАУ-аас 3, БНКУ-ын талаас 1 ялтанг шилжүүлэн авах ажлыг зохион байгуулсан.

3. “Төмөртэй орд” ХХК-ийн БНХАУ-ын хөрөнгө оруулагчдын нэхэмжлэлтэй арбитрын маргааны хэргийн шүүх хурлын дараа нэхэмжлэгч талаас гаргасан гомдлын асуудлаар Улсын ерөнхий прокурорын газраас ирүүлсэн албан бичгийг орчуулан, хариу тайлбар бэлтгэн, арбитрын бүрэлдэхүүнд хүргүүлж, арбитрын бүрэлдэхүүний зардлыг Засгийн газрын тогтоолоор батлуулсан.

“Гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой эрх зүйн маргаанаас урьдчилан сэргийлэх, маргааныг хэлэлцээний замаар шийдвэрлэх, маргаан үүсэхэд баримтлах журам”-ын төсөлд холбогдох байгууллагын саналыг авч байна.

4. Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн /ГОУХАН/ төслийн хоёр дахь үе шат дуусч байгаатай холбогдуулан хөндлөнгийн шинжээч нарыг хүлээн авч, уулзалт зохион байгуулж, төслийн үр дүн, үр нөлөөг дүгнэж, тус төслийн дараагийн шатны үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж, НҮБ-ын Хүн амын сантай хамтран “Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг чадавхийг бэхжүүлэх” төсөл, БНСУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Эрх зүйн шинэтгэл багц төслийг ШШГЕГ, ХСИС, ШШҮХ, АЕГ-т хэрэгжүүлэхээр бэлтгэж байна.

Ханнс-Зайделийн сантай “Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын цахим нэгтгэлийн систем” байгуулах төслийн зарим програм хангамжийг боловсруулах, үүнтэй холбоотой бусад ажлыг хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна.

БНХАУ-аас Монгол улсад олгох 1 тэрбум юанийн буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжүүлэх төслүүдийн саналыг холбогдох байгууллагаас авч Сангийн яаманд хүргүүлсэн бөгөөд БНХАУ-ын Нийгмийг аюулаас хамгаалах яамнаас Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2 сая долларын буцалтгүй тусламж үзүүлэх Нотломжид гарын үсэг зурсан.



захиргааны онцгой бүс Макаоод зохион байгуулагдсан Хөрш орнуудын шүүх болон хууль сахиулах байгууллагын дээд түвшний уулзалтад Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргыг оролцуулах ажлыг зохион байгуулав.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын Оросын Холбооны Улсад хийсэн айлчлалын бэлтгэл хангаж, зохион байгуулав.

## **ЗУРГАА. БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ, ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД:**

1. “Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийн мөрөөр авах арга хэмжээний тухай”, “Архивын салбарт хамтран ажиллах Монгол Улс, Оросын Холбооны Улсын хамтарсан комиссын Монголын хэсгийн бүрэлдэхүүн”-ийг шинэчлэн байгуулах тухай, “Улсын хэмжээнд зохион байгуулагдах аж ахуйн нэгжийн тооллогын тов”-ын тухай зэрэг Засгийн газрын 12 тогтоол, Ажил хүлээлцэх, хөрөнгө шилжүүлэх тухай, Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах журам, “Замын хөдөлгөөний дүрэм”-ийг шинэчлэн боловсруулах, Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг боловсруулах асуудлыг Хууль зүй, дотоод хэргийн хэргийн сайдын 64 тушаалаар батлуулсан.

"Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох журам"-ын дагуу өргөдөл гаргасан хохирогчдод хохирлыг олгох асуудлыг Орон тооны бус сангийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж, Хууль зүйн сайдын тушаалаар 16 хохирогчдод 51.2 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгохоор шийдвэрлэсэн.

2. Эрх зүйн сургалт, сурталчилгааны чиглэлээр 2016 онд харьяа агентлаг, байгууллагууд хандивлагч байгууллагатай хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг ТНБД-аар батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан. Тухайлбал Ханнс-Зайделийн сантай хамтран Монголын үндэсний радиогийн "Шинэ товчоо" радио зохиомжит нэвтрүүлгээр "Эрүүл мэндийн даатгалын тухай, Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай зэрэг хуулиар зохиомж бэлтгэн нэвтрүүлсэн.

“Захиргааны ерөнхий хуулийг сурталчлах, сургалт зохион байгуулах ажлын ерөнхий төлөвлөгөө”-г Ханнс-Зайделийн сантай байгуулсны дагуу тус сангаас хууль зүйн их, дээд сургуулиудын захиргааны эрх зүйн хичээлийн сургалтын хөтөлбөрт Захиргааны ерөнхий хуулийн агуулгыг оруулсан жишиг хөтөлбөрийг боловсруулж ирүүлсэн.

Мөн тус сангийн “Эрх зүйн боловсрол” академитай хамтран Захиргааны ерөнхий хуулиар яам, агентлагууд, нийслэл, дүүргүүдийн ЗДТГ, Захирагчийн ажлын алба, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлагуудын ажилтнуудад зориулсан 100 гаруй удаагийн сургалт зохион байгуулж, 7500 гаруй албан хаагчийг хамруулсан байна.

Захиргааны ерөнхий хуулиар яам, агентлагууд, нийслэл, дүүргүүдийн ЗДТГ, Захирагчийн ажлын алба, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлагуудын ажилтнуудад зориулсан 100 гаруй удаагийн сургалт зохион байгуулж,

хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үүрэг бүхий зэрэг дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулж, ажлын хэсгийн хурлыг зохион байгуулсан.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн.

Хүн худалдаалах гэмт хэрэг, Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр нэвтрүүлэг, шторкийг бэлтгэн Eagle TV, МҮОНТ, МNB зэрэг телевизүүдээр, олон нийтийн газарт LCD дэлгэцээр тогтмол гаргаж, гарын авлага, материалыг эмхэтгэн хэвлүүлж, паспортын хавчуургыг хэвлэн, хилийн боомтууд болон гадаад улсад суугаа элчин сайдын яамны консулын газарт хүргүүлсэн.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй сүм хийд, шашны байгууллагууд болон шашны урсгалын талаар судалгаа хийж, танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Хууль зүйн сайдын тушаалаар байгуулж, ажлын удирдамжийг аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нарт хүргүүлж, улсын хэмжээнд шалгалтын ажлыг зохион байгуулж, илтгэх хуудсыг УИХ-ын Өргөдлийн байнгын хороо, Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлд тус тус хүргүүлсэн.

Хууль зүйн сайдын тушаалаар Нотариатчийн мэргэшлийн шалгалтын товыг тогтоон, шалгалтыг Нотариатчийн мэргэшлийн хороотой хамтран 2016 оны 3 дугаар сард зохион байгуулсан.

Хууль зүйн сайдын баталсан удирдамжийн дагуу Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтэс, Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагуудын тус аймгууд дахь алба, нэгжийн үйл ажиллагаанд шалгалт хийж, дүнг танилцуулсан.

6. Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2015 оны 23 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Прокурорын хяналт, мониторингийн системээс шүүхэд шилжүүлсэн эрүүгийн 292 хавтаст хэргийн мэдээллийг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хорих, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны бүртгэлийн 5215 хоригдлын мэдээллийг Үндэсний дата төвд байрлах хууль сахиулах, шүүхийн байгууллагын нэгдсэн мэдээллийн санд байнгын баяжилт хийхээр тохируулан шилжүүлсэн.

#### **Нэг. Бодлого зохицуулалтын асуудлаар:**

Хууль зүйн сайд/хуучнаар/-аас өөрийн эрхлэх асуудлыг хүрээний харьяа агентлаг, байгууллагуудын дарга, захиралтай /Төсвийн шууд захирагчтай/ байгуулсан 2015 оны үр дүнгийн гэрээг дүгнэж, 2016 онд хууль зүйн сайд /хуучнаар/-тай байгуулах үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөөг хянан баталгаажуулсан.

Хил хамгаалах ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газар, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын

2016 оны МН/44, А/65, А/16, А/17, А/42, А/112, А/67 дугаар тушаалаар тус тус шинэчлэн боловсруулж батлуулсан.

Хууль зүйн сайдаас аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 2016 онд хамтран ажиллах гэрээний төслийг боловсруулж гэрээг 2015 оны 12 дугаар сарын 18-ны өдөр батлуулав. Мөн 2015 онд хамтран ажиллах гэрээний биелэлтийг нэгтгэн гаргаж мониторинг хийлгэж, гэрээний биелэлтэнд үнэлгээ хийсэн дүнг 2016 оны 1 дүгээр сарын 21-ны өдрийн 1/307-329 тоот албан бичгээр хүргүүлж ажиллаа.

Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн дарга, мэргэжилтнүүдэд зориулсан өргөтгөсөн 2016 оны сургалт-семинарын хөтөлбөрийг (Төрийн нарийн бичгийн даргын өгсөн чиглэлийн дагуу) боловсруулан батлуулж, сургалт, семинарыг 2016 оны 11 дүгээр сарын 30, 12 дугаар сарын 2-ны өдрүүдэд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хуульчдын танхимд зохион байгууллаа. Сургалтын хөтөлбөрийн агуулгад шинээр батлагдан хэрэгжиж буй Захиргааны ерөнхий хууль, Хууль тогтоомжийн тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэмжээ тогтоосон актын талаар болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг байгууллагуудын мэдээллийг тусгасан.

“Бүх нийтийн эрх зүйн боловсролын хөтөлбөр”-ийн үзэл баримтлалын хэлэлцүүлгийг Улаанбаатар, Хэнтий, Ховд, Өвөрхангай аймгуудад бүсчлэн зохион байгуулсан бөгөөд Улаанбаатар хот, 21 аймаг, бүх сумдын төрийн захиргааны байгууллага, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн төлөөллийг оролцуулан 800 гаруй хүн уг хэлэлцүүлэгт оролцож, санал бодлоо илэрхийллээ. Уг хөтөлбөрийг боловсруулах чиглэлээр Хууль зүй, дотоод хэргийн яам, Нээлттэй нийгэм форум 2017 онд хамтран ажиллах санамж бичгийн төсөл, хэлэлцүүлгээс гарах уриалгын төслийг ННФ-тай хамтран боловсрууллаа. 2016 оны 12 дугаар сарын 1-нд Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Баясгалан, ННФ-ын гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал нар санамж бичигт гарын үсэг зурж баталгаажуулсан.

### **ДОЛОО. ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛ, БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, ҮР ДҮНД ҮНЭЛГЭЭ ӨГӨХ, ДОТООД АУДИТ ХИЙХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД:**

1. Хууль зүйн яам, Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний 11 агентлаг, байгууллагын 2015 оны үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн болон Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт Хууль зүйн сайдын гүйцэтгэх арга хэмжээний хэрэгжилтийн байдал, Аймаг, нийслэлийн Засаг даргын Хууль зүйн сайдтай байгуулсан 2015 оны гэрээний хэрэгжилт, дээд газрын тогтоол, шийдвэр, Засгийн газрын тогтоолоор батлагдсан үндэсний 6 хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг ЗГХЭГ-т хүргүүлсэн.

Тус яаманд хэрэгжиж буй гадны төсөл, хөтөлбөрийн 2015 оны үйл ажиллагааны тайлан болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар баталсан харьяа агентлаг, байгууллагын хөгжлийн стратеги, хөтөлбөр болон харьяа агентлаг, байгууллага болон яамны зарим чиг үүрэгт хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн.

Хууль зүйн сайдын 2014 оны А/48 тушаалаар батлагдсан “Салбарын статистик мэдээллийн санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх, ашиглах журам”-ын дагуу Сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга болон газар, хэлтсийн дарга нарыг мэдээллээр хангаж байна.

Төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжийн дагуу Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх алба, ЦЕГ-ын “Цагаан шонхор” УҮГ-т шалгалт хийж, дүнг удирдлагад танилцуулсан.

2. Хууль зүйн сайд, Төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжийн дагуу дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийж, дүнг удирдлагад танилцуулж, зохих арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

“Архидан согтуурахтай тэмцэх сан”, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мэдээлэл сурталчилгааны хөтөлбөр”-ийн санхүүжилтээр 2015-2016 онд гэрээ байгуулан хамтран ажиллаж буй төрийн болон төрийн бус байгууллагын гэрээний хэрэгжилт, үр дүн, зэрэгт дотоод аудит хийж, дүнг танилцуулсан.

Хууль зүйн сайдын баталсан удирдамжийн дагуу Хил хамгаалах ерөнхий газар, Хилийн хангалт үйлчилгээний 243 дугаар ангийн санхүүгийн үйл ажиллагаанд хэсэгчилсэн шалгалт, ИХШХЕГ-ын Хяналт шалгалтын газарт чиг үүргийн үнэлгээ, төсөл хөтөлбөр, 4 агентлагийн санхүү, бүртгэл, үндсэн үйл ажиллагааны зарим чиг үүрэгт дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт, Хууль зүйн яамны жижиг мөнгөн сангийн 2016 оны орлого, зарцуулалтад хяналт шалгалт, Хууль зүйн яамны Төрийн сангийн 2016 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийж, дүнг удирдлагад танилцуулсан.

### **ДҮГНЭЛТ:**

Тус яам 2016 онд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл, Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн хөгжлийн цогц бодлого, Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх хүрээний асуудлаар УИХ, Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор 480 арга хэмжээг төлөвлөж, биелэлтийг тооцоход 98.1 хувь буюу 4.8 оноотой хэрэгжүүлэн ажилласан байна.

Хууль зүй, дотоод хэргийн яамны 2016 оны төлөвлөгөө зохих түвшинд хэрэгжсэн бөгөөд санхүүжилт шийдвэрлэгдээгүй, хамтран ажиллах байгууллагын зүгээс хариу хүлээгдсэн, хугацааг хойшлуулах санал ирүүлсэн зэрэг шалтгаанаар үнэлэгдээгүй, хэрэгжилт удаашралтай арга хэмжээ нь төлөвлөгөөний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлсөн байна.

Төлөвлөгөөний биелэлтийг 2015 онтой харьцуулахад 1.7%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Тус яам 2017 онд Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2017 оны Үндсэн чиглэл, Монгол Улсын Хууль тогтоомжийг 2016-2020 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэл, яамны стратеги, бүтцийн хөтөлбөр, холбогдох эрх зүйн баримт бичгүүдийн хүрээнд хууль тогтоомжийг боловсронгуй болгоход чиглэсэн бодлогыг тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ өгөх, удирдлагын шилдэг арга барил, туршлагыг нэвтрүүлэх, тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог хөгжүүлэх, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, ажилтнуудыг чадавхижуулах, хариуцлагажуулах, төсөвлөсөн хөрөнгө, нөөцийг зохистойгоор хуваарилан зохицуулах, олон улсын болон гадаад улс орнуудын ижил төрлийн байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх **зорилт, арга хэмжээг** хэрэгжүүлэн ажиллана. Үүнд:

- Хууль тогтоомжоос үүдэлтэй иргэдийг хохироосон хууль сахиулах байгууллагуудын алдаа гажуудлыг засч, эрх зүйн орчинг нь иргэндээ ойртсон, тогтвортой болгох, төрийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй түргэн шуурхай хүргэх зорилгоор Цагдаагийн албаны тухай, Прокурорын байгууллагын тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Хууль сахиулах ажиллагааны тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Төрийн бус байгууллагын тухай, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай зэрэг хуулийн төслүүдийг батлуулна.
- Эдийн засаг, бизнес, худалдаа, өмч, санхүүгийн эрх зүйн үндсийг боловсронгуй болгох зорилгоор Дампуурлын тухай, Арбитрын тухай хуулийн төслийг боловсруулж, холбогдох хуулиудын давхардал, хийдлийг арилгана;
- Батлагдан гарсан хуулийн дагуу түүнийг дагаж гарах журмуудыг боловсруулах, батлуулан, хэрэгжилтийг хангана.
- Бүх нийтийн эрх зүйн боловсрол хөтөлбөрийг боловсруулж батлуулан хэрэгжүүлж эхлэнэ.
- Захиргааны хэм хэмжээний актын санд дүн шинжилгээ хийж, хуулийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг авна.
- Төрөөс гэмт хэрэгтэй тэмцэх бодлогын баримт бичгийг батлуулан хэрэгжүүлнэ.
- Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хууль зүйн талаарх бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, орон нутгийн хууль зүйн албадын ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах.
- Хууль зүй, дотоод хэргийн салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төслийн хэрэгжилтийн явц, үр нөлөө, зорилгод хүрч байгаа

байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитыг тогтмол хийж  
гүйцэтгэнэ.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_